



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдварыг эрт илрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалт хийх удирдамжийг нэгдүгээр, ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалтад хэрэглэгдэх дардасны загварыг хоёрдугаар, ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээллийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тандалтын удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (Д.Нямхүү)-д үүрэг болгосугай.
3. Үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалтыг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан 2012 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлүүлэн, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалтын дүнг нэгтгэн тухайн оны 12 сард багтаан Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлд танилцуулж байхыг Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (Д.Нямхүү)-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР



16
Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...сарын... өдрийн 191-тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

**Үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар
хүний дархлал хомсдолын вирусийн халдвар илрүүлэх
тандалт хийх удирдамж**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү удирдамж нь ХДХВ-ийн халдварын тохиолдлыг үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар эрт илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, эргэн мэдээлэх болон хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг зохицуулна.

ХОЁР. ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДАХ ХҮРЭЭ

- 2.1. Эрүүл мэндийн яамны харьяа дараахь төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн клиник-биохими, иммунологийн лабораторт шинжилгээнд хамрагдаж байгаа болон мэс засал хийлгэх шаардлагатай 15-64 насны бүх хүмүүсийг жилд нэг удаа хамруулна. Үүнд:

- 2.1.1. Улсын Клиникийн Төв Эмнэлэг
- 2.1.2. Улсын Клиникийн Хоёрдугаар Эмнэлэг
- 2.1.3. П.Н Шастины нэрэмжит Төв Эмнэлэг
- 2.1.4. Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
- 2.1.5. Хавдар Судлалын Үндэсний Төв
- 2.1.6. Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв
- 2.1.7. Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв
- 2.1.8. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
- 2.1.9. Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

ГУРАВ. ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

- 3.1 Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ) нь хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдвар илрүүлэх тандалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.
- 3.2 ХӨСҮТ-ийн Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын лаборатор нь энэ удирдамжинд заагдсан ЭМЯ-ны харьяа дээр нэр дурдсан 9 төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдээс ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд

“эерэг” болон “эргэлзээтэй” гарсан сорьцонд баталгаажуулах шинжилгээг хийнэ.

- 3.3 ХӨСҮТ-ийн БЗДХ-ын лаборатор нь ХДХВ-ийн халдвар батлагдсан тохиолдолд шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба болон сорьц ирүүлсэн эмнэлгийн халдвар судлаач эмчид мэдээлнэ.
- 3.4 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба нь ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тусламж үйлчилгээний удирдамжийн дагуу эмнэлзүйн болон тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ТӨВ ЭМНЭЛЭГ БОЛОН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮД

- 5.1 ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалт хийх үйл ажиллагааг клиник-биохими, иммунологийн лабораторийг түшиглэн зохион байгуулна.
- 5.2 Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүд нь хоёрдугаар хавсралтаар баталсан дардас, гуравдугаар хавсралтаар баталсан мэдээллийн хуудсыг шаардлагатай тоо хэмжээгээр шинжилгээнд илгээж буй эмч нарт олгоно.
- 5.3 ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалт хийх үйл ажиллагаанд шаардагдах лабораторийн оношлуур, урвалж бодисыг тасралтгүй хангаж, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллана.
- 5.4 ХДХВ-ийн халдвар илрүүлэх тандалт хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулна.
- 5.5 ХДХВ-ийн халдвар эмнэлгээс шалтгаалах халдвар байдлаар тархах, эмнэлгийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байхдаа халдварт өртөхөөс сэргийлэх зорилгоор халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллана.
- 5.6 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний тайлан мэдээг холбогдох байгууллагад цаг тухайд нь тайлагнаж, мэдээний бодит байдлыг хангаж ажиллана.

ТАВ. ШИНЖИЛГЭЭНД ИЛГЭЭХ ЭМЧИЙН ҮҮРЭГ

- 5.1 Үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хийгдэх ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний зарчмыг баримтлан клиник-биохими, иммунологийн шинжилгээ хийлгэх болон мэс засал хийлгэхээр төлөвлөж буй үйлчлүүлэгчийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулна.

- 5.2 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдах хүмүүст ХДХВ, ДОХ-ын тухай болон ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаарх мэдээллийн хуудсыг уншуулан танилцуулж, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдах таниулсан зөвшөөрлийг үйлчлүүлэгчээс бичгээр авна.
- 5.3 Шинжилгээнд хамрагдах зөвшөөрлийг амбулаторийн болон мэс заслын эмч үйлчлүүлэгчийн картад хоёрдугаар хавсралтаар батлагдсан дардасын тэмдэглэгээний дагуу бөглөж хавсаргах бөгөөд үйлчлүүлэгч тухайн тэмдэглэгээн дээр гарын үсэг зурж баталгаажуулна.
- 5.4 Клиник-биохими, иммунологийн шинжилгээнд хамруулах бичгийг ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний бичгийн хамт тухайн үйлчлүүлэгчид өгч лабораторийн шинжилгээ авах өрөө рүү илгээнэ.
- 5.5 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг эмч чандлан хадгалж, нууц алдагдсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 5.6 Шинжилгээний хариу “сөрөг” гарсан тохиолдолд үйлчлүүлэгчид хариуг шууд өгнө.
- 5.7 Шинжилгээний хариу “эерэг” гарсан тохиолдолд шинжилгээний хариуг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны мэргэжлийн эмч нарын хяналтад шилжүүлж, шинжилгээний дараах зөвлөлгөө өгсний үндсэн дээр үйлчлүүлэгчид шинжилгээний хариуг өгнө.
- 5.8 Шинжилгээгээр ХДХВ-ийн халдвар илэрсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн эмнэлэгт хандах болсон эмгэгийг оношлох, эмчлэх, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг /амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх/ тухайн эмнэлэгт үзүүлнэ.
- 5.9 Шаардлагатай тохиолдолд ХДХВ, ДОХ-ын нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна.

ЗУРГАА : ШИНЖИЛГЭЭ АВАХ АРГАЧЛАЛ

- 6.1 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаж буй үйлчлүүлэгчээс “Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлийн стандарт” (MNS 4621:2008)–ыг мөрдөж цус авна.
- 6.2 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний сорьцонд хураагуур судаснаас 5-7 мл цусыг антикоагулянт агуулаагүй вакумтэйнерт тусад нь авна.
- 6.3 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний сорьцтой ажиллахдаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.

6.4 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний сорьцыг 2005 оны Стандарт ажиллагааны аргачлал буюу “Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээний тогтолцоо”-ны лабораторийн оношлогооны протоколын САА-МТ-010 болон САА-МТ-011-д заасны дагуу бэлдэнэ.

6.5 Шинжилгээ тавих:

6.5.1 Ялгасан ийлдсэнд шинжилгээг тавихдаа оношлуур үйлдвэрлэгчийн зааварчилгааг дагаж мөрдөнө.

6.5.2 Энгийн хурдавчилсан аргаар шинжилгээ тавих оношлуур нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна:

1. ХДХВ-1 болон ХДХВ-2-ыг хамтад нь илрүүлэх
2. Мэдрэг чанар нь $>99\%$
3. Өвөрмөц чанар нь $>99\%$
4. Эерэг мөн сөрөг урьдчилан тооцох чадвар нь $>99\%$
5. Захын цусыг ашиглах боломжтой
6. Тусгай тоног төхөөрөмж шаардагдахгүй байх
7. Хадгалах нөхцөл $1-30^{\circ}\text{C}$
8. Үйлдвэрлэгчээс заасан хадгалах хугацаа ≥ 18 сар
9. Шинжилгээний хариуг 30 минутын дотор гаргах боломжтой байх

6.6 Ийлдсийг хадгалахдаа цусны улаан эс оруулахгүйгээр автомат пипеткээр эсвэл дусаагуураар 1,5 мл-ийг болгоомжтой соруулан эппендорф фонд ялган авна.

6.6.1 Ялган авсан ийлдэстэй эппендорф дээр тэмдэглэгээ хийнэ.

6.6.2 Ийлдсийг шинжилгээ тавих хүртэл $2-8^{\circ}\text{C}$ хэмтэй хөргөгчинд 7 хоног хүртэл хугацаанд хадгалж болно.

6.6.3 Хэрэв ийлдсийг 7 хоногоос дээш хугацаанд хадгалах шаардлагатай бол -20°C хэмд хөлдөөж хадгална.

6.7 Шинжилгээг дүгнэх:

6.7.1 Хурдавчилсан оношлуурын хяналтын зурвас дээр улаан зурам тодроод, сорилын зурвас тодрохгүй бол урвал “сөрөг” гэж дүгнэнэ.


6.7.2 Хурдавчилсан оношлуурын хяналтын болон сорилын зурвас дээр аль алинд нь улаан зурам тодорвол урвал “эерэг” гэж дүгнэнэ.

6.7.3 Хурдавчилсан оношлуурын хяналтын болон сорилын зурвас дээр аль алинд нь улаан зурам тодрохгүй бол оношлуур ажиллахгүй байна гэж үзээд шинжилгээг давтан хийнэ.

6.8 Шинжилгээний хариуг мэдээлэх:

- 6.8.1 Шинжилгээний хариу “сөрөг” гарсан тохиолдолд шинжилгээнд илгээсэн эмчээр дамжуулан үйлчлүүлэгчид шууд өөрт нь мэдээлнэ.
- 6.8.2 Шинжилгээний хариу “эерэг” буюу хяналтын болон сорилын зурвас хоёул тод гарсан, эсвэл “эргэлзээтэй” буюу хяналтын зурвас тод, сорилын зурвас бүдэг гарсан тохиолдолд тухайн сорьцыг “Халдвартай болон халдвартай байж болзошгүй шинжлэгдэхүүн тээвэрлэх” журмын дагуу савлаж, дагалдах бичгийн хамт ХӨСҮТ-ийн БЗДХ-ын лабораторт батлах шинжилгээнд илгээнэ.
- 6.8.3 ХӨСҮТ-ийн БЗДХ-ын лабораторт батлагдсан “сөрөг” шинжилгээний хариуг хүлээн авсан лабораторийн эмч шинжилгээнд илгээсэн эмчээр дамжуулан үйлчлүүлэгчид өөрт нь мэдээлнэ.
- 6.8.4 ХӨСҮТ-ийн БЗДХ-ын лабораторт батлагдсан “эерэг” шинжилгээний хариуг сорьц ирүүлсэн эмнэлгийн халдвар судлаач эмчээр дамжуулан үйлчлүүлэгчийг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны албаны хяналтанд оруулна.

Бүдүүвч 1.ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний бүдүүвч



ДОЛОО. ЛАБОРАТОРИЙН ЭМЧИЙН ҮҮРЭГ

- 7.1 Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх, эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай Эрүүл мэндийн Сайдын 165 тоот тушаалын 2-р хавсралтын 9 дүгээрт заасан “Лабораторт баримтлах халдварын эсрэг дэглэм”-ийг чанд баримтлан ажиллана.
- 7.2 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийх болон дүгнэх явцад хяналт тавина.

- 7.3 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд шаардагдах лабораторийн оношлуур, урвалж бодисын хэрэгцээг тодорхойлох, захиалах, хадгалах ажлыг хариуцна.
- 7.4 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний хариу "сөрөг" гарсан тохиолдолд хариуг шинжилгээнд илгээсэн эмчид өгнө. Харин "эерэг" эсвэл "эргэлзээтэй" гарсан тохиолдолд тухайн сорьцыг "Халдвартай зүйлс болон цусны ийлдэс зэрэг оношлогооны дээжүүдийг аюулгүй тээвэрлэх журам"-ын дагуу савлаж, дагалдах бичгийн хамт ХӨСҮТ-ийн БЗДХ-ын лабораторт батлах шинжилгээнд илгээнэ.
- 7.5 ХӨСҮТ-ийн БЗДХ-ын лабораториос баталгаажсан "сөрөг" хариуг шинжилгээнд илгээсэн эмчид өгнө.
- 7.6 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг чандлан хадгалж, нууц алдагдсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 7.7 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний тайланг лабораторийн эмч баталгаажуулан тухайн эмнэлгийн халдвар судлаач эмчид өгнө.

НАЙМ. ЛАБОРАНТИЙН ҮҮРЭГ

- 8.1 Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх, эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай Эрүүл мэндийн Сайдын 165 тоот тушаалын 2-р хавсралтын 9 дүгээрт заасан "Лабораторт баримтлах халдварын эсрэг дэглэм"-ийг чанд баримтлан ажиллана.
- 8.2 Тухайн эмнэлгийн тасаг нэгжээс ирсэн сорьцыг хүлээн авч, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хийнэ.
- 8.3 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний протокол хөтөлж, шинжилгээний хариуг холбогдох тасаг нэгжид олгоно.
- 8.4 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хэрэглэгдсэн лабораторийн оношлуур, урвалж бодисын зарцуулалтын тайланг гаргана.
- 8.5 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний тайланг сар бүр нэгтгэн гаргаж лабораторийн эмчид хүлээлгэн өгнө.
- 8.6 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг чандлан хадгалж, нууц алдагдсан тохиолдолд хуулийн дагуу зохих хариуцлага хүлээнэ.

ЕС. ХАЛДВАР СУДЛААЧ ЭМЧИЙН ҮҮРЭГ

- 9.1 ХДХВ-ийн халдварын тархалтын тандалт хийх удирдамжийн хэрэгжилтийг тухайн эмнэлгийн халдвар судлаач эмч удирдан зохион байгуулж ажиллана.
- 9.2 Шинжилгээний хариу "зерэг" нь баталгаажсан тохиолдолд үйлчлүүлэгчийг ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны албаны хяналтад хамруулна.
- 9.3 ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг чандлан хадгалж, нууц алдагдсан тохиолдолд хуулийн дагуу зохих хариуцлага хүлээнэ.

АРАВ. БҮРТГЭЛ МЭДЭЭЛЭЛ

- 10.1 Эрүүл мэндийн сайдын 2010 оны 02-р сарын 02-ны өдрийн 34 тоот тушаалын 4-р хавсралтын ЭМТ304.6.1, ЭМТ304.6.2 дагуу лабораторт хийгдсэн ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний тайланг лабораторийн эмч баталгаажуулан тухайн эмнэлгийн халдвар судлаач эмчид өгнө.
- 10.2 Тухайн эмнэлгийн халдвар судлаач эмч ХДХВ-ын халдвар илрүүлэх шинжилгээний тайланг нэгтгэн дараа сарын 10-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны албанд ирүүлнэ.
- 10.3 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба нь шинжилгээний тайланг нэгтгэн тухайн оны эцэст Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлд танилцуулна.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
..6.. сарын...4... өдрийн ...19/... тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

**Үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар
хүний дархлал хомсдолын вирусийн халдвар илрүүлэх
тандалтад хэрэглэгдэх дардасны загвар**

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний талаарх мэдээлэл авч шинжилгээ
өгөхөөр шийдвэр гаргасныг баталгаажуулах тэмдэглэгээний дардасны загвар:

Эмнэлгийн нэр, лого

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний
талаарх мэдээлэлтэй танилцаж, шинжилгээнд
хамрагдахыг зөвшөөрсөн.

Үйлчлүүлэгч/гарын үсэг/

Эмч...../гарын үсэг/

.....онсар.....өдөр

Дардасыг тухайн үйлчлүүлэгчийн амбулаторийн карт дээр тэмдэглэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...сарын... өдрийн ... тоот
тушаалын гуравдугаар хавсралт

ХДХВ, ДОХ-ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Танд энэ өдрийн мэндийг хүргэж, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд үнэ төлбөргүй хамрагдахыг санал болгож байна.

ХДХВ гэдэг нь Хүний Дархлал Хомсдолын Вирус гэсэн үгийн товчлол.

ДОХ гэдэг нь Дархлалын Олдмол Хомсдолын товчилсон нэр юм.

ХДХВ нь дархлалын тогтолцоог дарангуйлснаар бие махбод аливаа халдвартай тэмцэх чадваргүй болж ДОХ-ыг үүсгэдэг.

ХДХВ-ийн халдвартай хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд ороход үрийн буюу үтрээний шингэнээр, зүү тариур дамжуулан хэрэглэх, халдвартай цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх зэрэг тохиолдолд цусаар халдвар дамжина.

Мөн халдвартай жирэмсэн эхээс урагт, төрөх үед болон эхийн хөхний сүүгээр хүүхдэд ХДХВ дамжин халдварладаг.

Халдвар авснаас хойш ДОХ-ын шинж тэмдэг илрэх хугацаа хүн бүрт харилцан адилгүй байдаг. ХДХВ-ийн халдвартай ихэнх хүмүүс эрүүл харагдах учир хэн нэгэн хүнийг гаднаас нь хараад халдвартай гэж хэлэх боломжгүй. Шинж тэмдэг илрээгүй ч ХДХВ-ийн халдвартай хүн халдвараа бусдад тараадаг.

ХДХВ-ийн халдвар авсан эсэхээ мэдэх цорын ганц арга нь ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэх юм.

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдах нь өөртөө итгэлтэйгээр амьдарч гэр бүл, хайртай дотны хүмүүсээ халдвар авах эрсдэлээс хамгаалж буй таны үүрэг хариуцлага юм.

Энд нэг анхаарах зүйл бий. Халдвар авснаас хойш 3-6 сарын хугацаанд шинжилгээнд ХДХВ-ийн халдвар илрэхгүй байж болох ба үүнийг "цонх үе" гэдэг. Хэрэв та дээр дурьдсан халдвар авах эрсдэлд өртөж байсан бол "Цонх үе"-ийг тооцон давтан шинжилгээ өгч эрүүл гэдгээ заавал баталгаажуулаарай.

Халдвартай хүн ХДХВ-ийн халдвартайгаа эрт мэдсэнээр эмчийн хяналтанд орж, эмчилгээнд эрт хамрагдан урт удаан хугацаанд амьдрах боломжтой юм. Жирэмсэн эх ХДХВ-ийн халдвартайгаа мэдсэнээр "Эхээс хүүхдэд халдвар дамжихаас сэргийлэх арга хэмжээ"-нд хамрагдаж эрүүл хүүхэд төрүүлэх боломжтой.

ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний хариу "сөрөг" байх нь халдваргүй, "эерэг" байх нь ХДХВ-ийн халдвартай болохыг илэрхийлнэ.